

## ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ТЕЛЕВИЗҮҮДЭЭР 2023 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРАЛД НЭВТРҮҮЛСЭН ХҮҮХДИЙН НЭВТРҮҮЛГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН ДҮГНЭЛТ

Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 01 тоот тогтоолоор батлагдсан “Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”-аар Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн телевиз нь жилд 130 цагаас багагүй хугацааны бага, өсвөр насны хүүхэд зориулсан нэвтрүүлэг, 90 цагаас багагүй хугацааны балчир насны хүүхдэд зориулсан нэвтрүүлэг тус тус нэвтрүүлэх үүрэг хүлээлгэсэн.

### БАГА БУЮУ 3+ НАСНЫ НЭВТРҮҮЛЭГ НЭВТРҮҮЛСЭН БАЙДАЛ

(2023 оны 1 дүгээр улирал)

Телевизийн нэр	2023 он 1 сар	2023 он 2 сар	2023 он 3 сар	Нийт
Малчин	19:19:47	17:17:56	22:08:41	58:46:24
TM	13:00:22	8:58:55	12:48:55	34:48:12
ETV	12:02:44	7:30:33	13:08:40	32:41:57
Боловсрол суваг	11:05:35	6:04:12	08:09:05	25:18:52
Монгол	7:37:53	5:30:09	08:41:35	21:49:37
Сүлд	6:21:33	4:50:19	05:58:42	17:10:34
TB5	9:40:13	0:43:57	00:00:00	10:24:10
Central	0:47:05	1:37:35	01:31:40	3:56:20
UBS	0:00:00	2:36:18	00:00:00	2:36:18
TB9	0:31:10	0:31:43	00:00:00	1:02:53
TB8	0:00:00	0:54:13	00:00:00	0:54:13
TenGer	0:00:00	0:00:00	0:47:05	0:47:05
Стар	0:00:00	0:36:10	00:00:00	0:36:10
25-р суваг	0:00:00	0:00:00	00:00:00	0:00:00
C1	0:00:00	0:00:00	00:00:00	0:00:00
NTV	0:00:00	0:00:00	00:00:00	0:00:00
SBN	0:00:00	0:00:00	00:00:00	0:00:00
Ийгл ньюс	0:00:00	0:00:00	00:00:00	0:00:00

Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн 18 телевизээс 2023 оны 1 дүгээр улирлын дүнгээр Малчин, TM, ETV, Боловсрол суваг, Монгол телевизүүд балчир насны хүүхдэд зориулсан нэвтрүүлэг 20 цагаас дээш цагаар нэвтрүүлсэн байгаа нь сайшаалтай байна. Эдгээр телевизүүд бусад улирлуудад дунджаар энэ цагаа бууруулахгүй байвал жилд нэвтрүүлэх шаардлагыг бүрэн хангахаар байна. Сүлд, TB5 телевизүүд үлдсэн хугацаанд нэвтрүүлгийн цагаа нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Харин UBS, TB9, TenGer, Стар, 25-р суваг, C1, NTV, SBN, Ийгл ньюс телевизүүд балчир насны хүүхдэд зориулсан тогтсон нэвтрүүлэггүй байгаа нь хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлээгүй үйлдэл болж байна.

## БАЛЧИР БУЮУ 3+ НАСНЫ ХҮҮХДЭД ЗОРИУЛСАН НЭВТРҮҮЛЭГ НЭВТРҮҮЛЭЛТ

(2022 он болон 2023 оны 1 дүгээр улиралд нэвтрүүлсэн байдлын харьцуулалт)

Телевизийн нэр	2022 он 1 сар	2022 он 2 сар	2022 он 3 сар	2023 он 1 сар	2023 он 2 сар	2023 он 3 сар
Малчин	00:00:00	00:00:00	00:00:00	19:19:47	17:17:56	22:08:41
TM	14:10:04	13:06:23	15:34:12	13:00:22	8:58:55	12:48:55
ETV	04:30:48	01:56:28	03:20:50	12:02:44	7:30:33	13:08:40
Боловсрол суваг	00:00:00	00:00:00	24:40:30	11:05:35	6:04:12	08:09:05
Монгол	03:14:36	05:20:34	06:02:55	7:37:53	5:30:09	08:41:35
Сүлд	00:00:00	00:00:00	00:00:00	6:21:33	4:50:19	05:58:42
TB5	00:00:00	00:00:00	04:17:21	9:40:13	0:43:57	00:00:00
Central	00:00:00	00:00:00	00:00:00	0:47:05	1:37:35	01:31:40
UBS	00:00:00	00:00:00	00:00:00	0:00:00	2:36:18	00:00:00
TB9	00:00:00	00:00:00	00:00:00	0:31:10	0:31:43	00:00:00
TB8	00:00:00	00:00:00	00:00:00	0:00:00	0:54:13	00:00:00
TenGer	00:00:00	00:00:00	00:00:00	0:00:00	0:00:00	0:47:05
Стар	00:00:00	00:00:00	00:00:00	0:00:00	0:36:10	00:00:00
25-р суваг	03:14:11	02:02:11	01:35:24	0:00:00	0:00:00	00:00:00
C1	00:00:00	00:00:00	00:00:00	0:00:00	0:00:00	00:00:00
NTV	00:00:00	00:00:00	00:00:00	0:00:00	0:00:00	00:00:00
SBN	00:00:00	00:00:00	00:00:00	0:00:00	0:00:00	00:00:00
Ийгл ньюс	00:00:00	00:00:00	00:00:00	0:00:00	0:00:00	00:00:00

Дээрх хүснэгтэд энэ оны 1 дүгээр улиралд балчир насны хүүхдэд зориулсан нэвтрүүлэг нэвтрүүлсэн байдлыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулан гаргалаа. Малчин, Сүлд, Central, TB5 телевизүүд өнгөрсөн оны 1 дүгээр улирлын дүнгээр балчир насны хүүхдэд зориулсан нэвтрүүлэггүй, нэвтрүүлэлт нь хангалтгүй байсан бол энэ оны байдлаар балчир насны хүүхдэд зориулсан нэвтрүүлэгтэй болж тогтмол нэвтрүүлж эхэлсэн сайн үзүүлэлт үзүүлсэн байна.

TM, ETV, Боловсрол суваг, Монгол телевиз нь балчир насны хүүхдэд зориулсан нэвтрүүлэг тогтмол нэвтрүүлж байгаа нь үнэхээр сайшаалтай байна.

Харин 25-р суваг телевиз өнгөрсөн онд балчир насны хүүхдийн нэвтрүүлэгтэй байсан бол энэ онд энэ төрлийн нэвтрүүлэг нэвтрүүлээгүй байгаадаа анхаарч ажиллах шаардлагатай байна.

**БАГА, ӨСВӨР НАСНЫ БУЮУ 6+, 12+ НЭВТРҮҮЛЭГ НЭВТРҮҮЛСЭН ЦАГ**  
(2023 оны 1 дүгээр улирал)

Телевизийн нэр	2023 он 1 сар	2023 он 2 сар	2023 он 3 сар	Нийт
SBN	19:02:22	20:21:08	24:47:46	64:11:16
TB5	18:09:18	14:06:51	30:20:41	62:36:50
Боловсрол суваг	16:53:14	12:46:52	20:55:54	50:36:00
TB8	19:06:18	10:58:44	17:05:18	47:10:20
Стар	7:52:28	4:27:02	24:56:33	37:16:03
ETV	9:19:38	6:32:13	07:10:25	23:02:16
Сүлд	11:35:44	5:21:45	05:38:41	22:36:10
C1	6:20:17	7:40:10	06:02:28	20:02:55
TM	5:46:22	1:37:17	01:51:24	9:15:03
25-р суваг	3:47:33	1:12:29	02:56:46	7:56:48
UBS	2:18:04	0:00:00	02:55:41	5:13:45
TB9	1:43:25	0:29:34	00:20:41	2:33:40
Монгол	0:44:15	0:28:33	00:00:00	1:12:48
NTV	0:52:10	0:00:00	00:00:00	0:52:10
Central	0:00:00	0:00:00	00:00:00	0:00:00
Ийгл ньюс	0:00:00	0:00:00	00:00:00	0:00:00
Малчин	0:00:00	0:00:00	00:00:00	0:00:00
TenGer	0:00:00	0:00:00	00:00:00	0:00:00

Энэ оны 1 дүгээр улирлын байдлаар бага, өсвөр буюу 6+, 12+ насны хүүхдэд зориулсан нэвтрүүлэг нэвтрүүлсэн байдлаар SBN, TB5, Боловсрол суваг, TB8, Стар телевизүүд 30 цагаас дээш цаг нэвтрүүлсэн байгаа нь шаардлага хангасан явцтай байгаа бол ETV, Сүлд телевизүүд үлдсэн хугацаанд энэ төрлийн нэвтрүүлэг нэвтрүүлэлтээ нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Дараах хүснэгтэд 2022 он болон 2023 оны 1 дүгээр улиралд бага, өсвөр буюу 6+, 12+ насны хүүхдэд зориулсан нэвтрүүлэг нэвтрүүлсэн байдлыг харьцуулан авч үзлээ.

**БАГА, ӨСВӨР БУЮУ 6+, 12+ НАСНЫ ХҮҮХДЭД ЗОРИУЛСАН НЭВТРҮҮЛЭГ НЭВТРҮҮЛЭЛТ**  
(2022 он болон 2023 оны 1 дүгээр улирлын дүнгийн харьцуулалт)

Телевизийн нэр	2022 он 1 сар	2022 он 2 сар	2022 он 3 сар	2023 он 1 сар	2023 он 2 сар	2023 он 3 сар
SBN	18:22:43	15:10:12	17:56:19	19:02:22	20:21:08	24:47:46
TB5	00:00:00	00:00:00	00:00:00	18:09:18	14:06:51	30:20:41
Боловсрол	00:37:02	01:01:05	01:59:54	16:53:14	12:46:52	20:55:54
TB8	00:45:42	00:00:00	00:00:00	19:06:18	10:58:44	17:05:18
Стар	00:00:00	05:49:28	06:45:53	7:52:28	4:27:02	24:56:33
ETV	09:09:39	05:36:26	04:17:07	9:19:38	6:32:13	07:10:25
Сүлд	10:32:50	10:18:56	11:13:17	11:35:44	5:21:45	05:38:41
C1	00:00:00	00:00:00	00:00:00	6:20:17	7:40:10	06:02:28
TM	04:58:41	02:16:28	04:15:24	5:46:22	1:37:17	01:51:24

25-р суваг	00:19:12	00:15:25	00:00:00	3:47:33	1:12:29	02:56:46
UBS	04:29:43	01:50:15	03:11:59	2:18:04	0:00:00	02:55:41
TB9	07:31:55	00:34:12	00:23:59	1:43:25	0:29:34	00:20:41
Монгол	00:44:11	02:27:17	04:08:15	0:44:15	0:28:33	00:00:00
NTV	00:15:00	00:14:57	00:00:00	0:52:10	0:00:00	00:00:00
Малчин	09:56:33	09:05:07	09:34:55	0:00:00	0:00:00	00:00:00
Central	00:00:00	00:00:00	00:00:00	0:00:00	0:00:00	00:00:00
TenGer	00:00:00	00:00:00	00:00:00	0:00:00	0:00:00	00:00:00
Ийгл ньюс	00:00:00	00:00:00	00:00:00	0:00:00	0:00:00	00:00:00

Дээрх хоёр хүснэгтээс харахад Боловсрол суваг телевиз аль аль насны хүүхдэд зориулсан нэвтрүүлэг шаардлага хангах хэмжээнд нэвтрүүлж хууль тогтоомжийн шаардлагыг биелүүлсэн байна. ТВ5, Стар, С1 телевиз бага насны хүүхдэд зориулсан нэвтрүүлэг шинээр бэлтгэн нэвтрүүлж эхэлсэн нь сайшаалтай байна. Тэр дундаа С1 телевизийн бэлтгэн нэвтрүүлсэн “Гайхамшигт жижигхэн хүмүүс” шоу нэвтрүүлэг нь хүүхдэд зориулсан нэвтрүүлгийг шинэ түвшинд хүргэхэд ач холбогдолтой гэж үзэж байна.

Харин TenGer, Ийгл ньюс, Central, NTV телевизүүд хүүхдэд зориулсан нэвтрүүлэг байхгүй байсаар байгаадаа дүгнэлт хийж хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллах шаардлагатай байна.

Бусад телевизүүдийн хувьд аль нэг насны ангиллын хүүхдэд зориулсан нэвтрүүлэг тодорхой хэмжээнд нэвтрүүлсэн ч шаардлага хангасан хэмжээнд хүрэхгүй байгааг цаашид анхаарч тогтмол нэвтрүүлэх шаардлагатай байна.

### Арилжааны телевиз

Арилжааны телевизүүдийн хувьд хүүхдэд зориулсан нэвтрүүлэг заавал бэлтгэн нэвтрүүлэх үүрэг хүлээдэггүй ч MNC, Гандан ТВ, Мянгат малчин, Суваг 1 телевизүүд тодорхой хэмжээний хүүхдэд зориулсан нэвтрүүлэг нэвтрүүлж байгаа нь сайшаалтай юм.

БНСУ зэрэг гадаадын зарим улс орнуудын хувьд зөвхөн өөрсдийн дотоодын хүүхдийн нэвтрүүлгийг л телевизээр нэвтрүүлэх зохицуулалттай байна. Манай улсын хувьд гадаадын хүүхдийн нэвтрүүлэгт хязгаарлалт тогтоох зэрэг хуулийн зохицуулалт байдаггүй боловч “Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”-аар заавал нэвтрүүлэх үүрэг хүлээлгэсэн нэвтрүүлгийн цагийг тооцохдоо балчир буюу 3+ насны хүүхдэд зориулсан бүтээл нь зөвхөн Монгол бүтээл байна гэснээр хүүхдийг багаас нь үндэсний үзэл, соёлоор хүмүүжүүлэх цаашлаад үндэсний бүтээлийг дэмжин хамгаалах зорилготой юм.

Телевизүүдийн хувьд хүүхдэд зориулсан нэвтрүүлэг бүтээхэд хүүхдийн зохиолчоос эхлээд мэргэжлийн боловсон хүчин ховор, өртөг өндөртэй, хүүхдийн нэвтрүүлгийг ивээн тэтгэгч олдоггүй зэрэг олон асуудал бэрхшээл байдаг талаар дурддаг. Гадаадын өндөр чанарын хүүхдийн бүтээл, нэвтрүүлэгтэй өрсөлдөх түвшний, тэднийг орлохуйц үндэсний хүүхдийн контент бүтээх нь дан ганц телевизийн үйлчилгээ эрхлэгчийн хийж гүйцэтгэх ажил биш бөгөөд төр, засгийн зүгээс бодлогын болоод санхүүгийн хувьд дэмжих зайлшгүй шаардлагатай гэдэг нь харагдаж байна.